210303	Цэвэр, бохир ус	920,000.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>80,250,600.00</b>	<b>76,349,930.00</b>
210401	Бичиг хэрэг	6,262,500.00	6,129,700.00
210402	Тээвэр, шатахуун	37,687,800.00	37,074,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,822,000.00	3,526,980.00
210404	Ном, хэвлэл	931,600.00	746,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,773,000.00	9,101,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,773,700.00	19,770,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>74,983,100.00</b>	<b>68,786,189.50</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,670,600.00	28,490,347.50
210502	Хоол, хүнс	40,470,700.00	34,929,842.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,841,800.00	5,366,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>31,534,500.00</b>	<b>25,241,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,931,000.00	15,124,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,583,300.00	80,000.00
210604	Урсгал засвар	11,020,200.00	10,036,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,953,500.00</b>	<b>6,386,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,953,500.00	6,386,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,999,900.00</b>	<b>4,847,380.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,067,400.00	1,812,560.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,886,400.00	1,555,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	339,300.00	193,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	175,000.00	78,010.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	176,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,717,800.00	957,000.00

**Сагил сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210807	Газрын төлбөр	638,000.00	152,260.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>84,561,800.00</b>	<b>60,837,050.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,947,300.00	54,026,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,614,500.00	6,810,450.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>57,596,700.00</b>	<b>56,448,700.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>57,596,700.00</b>	<b>56,448,700.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,593,300.00	31,593,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,122,400.00	22,122,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,881,000.00	2,733,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>75,400,000.00</b>	<b>65,999,800.00</b>
223001	Бусад хөрөнгө	75,400,000.00	65,999,800.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>50,000,000.00</b>	<b>0.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	50,000,000.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,335,216,600.00</b>	<b>2,221,885,157.57</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,357,034,200.00</b>	<b>1,323,337,071.31</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,284,684,000.00	1,250,986,895.31
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	72,350,200.00	72,350,176.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>887,302,900.00</b>	<b>819,665,647.26</b>
320001	Орон нутгийн төсвөөс	887,302,900.00	819,665,647.26
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>24,759,700.00</b>	<b>18,902,580.00</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,759,700.00	18,902,580.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>66,119,800.00</b>	<b>59,979,859.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,400,000.00	59,979,859.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	30,719,800.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	22,065,182.40
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	96,880,811.97
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>624.00</b>	<b>624.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>6.00</b>	<b>6.00</b>
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>112.00</b>	<b>112.00</b>
620001	Удирдах ажилтан	13.00	13.00
620002	Гүйцэтгэх ажилтан	63.00	63.00
620003	Үйлчлэх ажилтан	23.00	23.00
620004	Гэрээт ажилтан	13.00	13.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>394.00</b>	<b>394.00</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>286.00</b>	<b>286.00</b>
630001	Төрийн өмчит ЕБС	286.00	286.00
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>108.00</b>	<b>108.00</b>
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	108.00	108.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>112.00</b>	<b>112.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	32.00	32.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4.00	4.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19.00	19.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	29.00	29.00
650010	Гэрээт ажилтан	10.00	10.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.00	8.00

## 2.6. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>243,433,686.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>243,433,686.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>206,727,412.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>92,671,343.00</b>
210101	Үндсэн цалин	25,319,843.00
210102	Нэмэгдэл	67,351,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>11,456,262.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,456,262.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>159,295.00</b>
210302	Түлш, халаалт	159,295.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,335,859.00</b>
210401	Бичиг хэрэг	1,027,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,684,359.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	530,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,094,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>79,711,247.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70,148,807.00
210502	Хоол, хүнс	9,562,440.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,200,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,200,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,289,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,289,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,904,406.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,950,906.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,953,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>36,706,274.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>32,900,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,900,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,806,274.00</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	974.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,805,300.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>256,420,939.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>256,420,939.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	22,859,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,664,510.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	195,897,429.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>12,987,253.00</b>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,987,253.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагил сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагил сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 1/46 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Шалгагдагч этгээд, түүний орчин ба дотоод хяналт

Сагил сумын Засаг дарга нь “Байгалийн баялаг, орон нутгийн нөөц боломжид түшиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтэц, аялал жуулчлал хөгжсөн, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан бүхий, хүний хөгжлийг дээдэлсэн, чинээлэг иргэдтэй сум болно” гэсэн гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлэх
- Байгаль хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх
- Орон нутагт дэд бүтэц, бизнесийн орчныг сайжруулах
- Байгалийн баялаг, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх
- Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган чанар хүртээмжийг дээшлүүлэх
- Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Шалгагдагч этгээдийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Сагил сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагил сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 36.0 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,604.3 сая төгрөгийн 1 хувь буюу 36.0 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 28.8 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Сагил сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 792.3 сая төгрөгөөр буюу 15.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/сая.төгрөг/
Мөнгөн хөрөнгө	463.8	866.0	402.2
Авлага	178.2	279.8	101.6
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	165.8	175.7	9.9
Үндсэн хөрөнгө	4,565.7	4,955.9	390.2
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>5,029.6</b>	<b>5,821.9</b>	<b>792.3</b>
Нийт өр төлбөр	12.6	4.1	-8.5
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,016.9	5,817.8	800.9
Засгийн газрын хувь оролцоо	5,016.9	5,817.8	800.9
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,029.6</b>	<b>5,821.9</b>	<b>792.3</b>

Эх сурвалж: Сагил сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 866.0 сая төгрөг болж 402.2 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлого, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эрүүл мэндийн төвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

#### **Сагил сумын Эрүүл мэндийн төв:**

-Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин шуудан холбоо, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлыг шууд зардалд бүртгэсэн 23.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг залрууллаа.

### 3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 279.8 сая төгрөг болж 101.6 сая төгрөгөөр өссөн нь Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 175.7 сая төгрөг болж 9.9 сая төгрөгөөр өссөн нь Соёлын төв, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,955.9 сая төгрөг болж 390.2 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн төсвөөр бэлтгэсэн, хандив тусламжаар хүлээн авсан үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,817.8 сая төгрөг болж 800.9 сая төгрөгөөр буюу 15.9 хувиар өссөн байна

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,050.2 сая төгрөгөөр буюу 30.6 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 337.3 сая төгрөгөөр буюу 10.3 хувиар өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга 1.8 сая төгрөгөөр хийгдсэн байна.

### 3.5.5 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 258.9 сая, татварын бус орлого 732.7 сая, тусламж санхүүжилтийн орлого 3,487.5 сая, нийт 4,4479.1 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

### 3.5.6 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 50.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

#### Аудитын илрүүлэлт:

##### Сагил сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:

-Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7 дахь хэсэгт "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг хууль тогтоомжид зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно", Хууль зүйн сайд, Сангийн сайдын 152 дугаар хамтарсан тушаалаар баталсан журмын 2.9 дэх заалтад "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан олгосон хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулах, уг хөрөнгө олгогдоогүй байхад урьдчилан зардал гаргахыг хориглоно" гэж заасныг зөрчин Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Түргэн суманд туршлага судлах ажилд зарцуулсныг баримтжуулсан ажлын тайлангүй бензин шатахууны зардалд 0.02 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан алдаа зөрчилд албан шаардлага өглөө.

##### Сагил сумын Эрүүл мэндийн төв:

-Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 зүйлийн 20.1.4 заалтад "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.5 дахь заалтад "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчин ажилтнаас суутгах сахилгын шийтгэлийн суутгал 0.2 сая төгрөгийн өглөгийг цалингийн зардлаас шилжүүлснийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчин хүнсний материалын тооллогоор дутагдсан 0.5 сая төгрөгийн 55 кг махны үнийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

-Сагил сумын Эрүүл мэндийн төв нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг үндэслэн Ковид-19 цар тахлын холбогдуулан олгосон санхүүжилтээс 49.6 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна. Цаашид Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 377/А99 дүгээр тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөмж болгов.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сагил сумын 2021 оны төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 2/05 дугаар тогтоолоор 2,258.1 сая төгрөгөөр баталж 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 4/02 дугаар тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 77.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,335.2 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,335.2 сая төгрөгийн төсөв баталснаас 1,357.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 887.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 24.8 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 66.1 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,357.0 сая, орон нутгийн төсвөөс 899.4 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 18.9 сая, төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 59.9 сая, нийт 2,400.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,147.1 сая төгрөгийг зарцуулж улсын төсөвт 33.7 сая, орон нутгийн төсөвт 70.5 сая, нийт 104.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,147.1 сая төгрөг буюу 91.9 хувьтай байгаа нь зардлыг 188.1 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Сагил сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай 04/02 дугаар тогтоолд зааснаар Сагил сумын Засаг дарга тайлант онд 41.5 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 348.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 838.5 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 37.7 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс ирсэн хандив 22.9 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 195.8 сая, нийт 256.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 243.4 сая төгрөгийг зарцуулж Эрүүл мэндийн төв 13.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. Сагил сумын Засаг даргын тамгын газрын авлагын эхний үлдэгдэлд хувь хүмүүсээс авах 6,400.0 мянган төгрөгийн авлагыг тайлант онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тухай 2021 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 1/26 дугаар тогтоолын дагуу бууруулжээ. Аудитын хугацаанд тухайн авлага үндэслэлгүй буурсан гэсэн гомдол ирсэн тул холбогдох материалыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр болов.

2. Сумын иргэдийн хурлын 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 4/02 дугаар тогтоолоор баталсан Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн 23.0 сая төгрөгийн 4 ажлыг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч гүйцэтгэсэн байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг зөрчсөн байж болзошгүй тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр болов.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Сагил сумын Засаг даргын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 115, хугацаа хоцроож 40 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөс зориулалт бус зардал гаргасан зөрчилд зөвлөмж өгснийг Сагил сумын Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 1/77 албан бичиг биелэлтийг ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А/43 дугаар захирамжаар сумдын Засаг даргын тамгын газрын, багийн бүтэц орон тоог батлахдаа гэрээт ажилтны орон тоог батлаагүй байна.

Сагил сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын 160.1 сая төгрөгийн авлага тусгагдсан байна. 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

### **3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар**

Сагил сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 5 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 73.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 23.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 0.7 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.02 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 49.6 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ИТХ	1	0.02					1	0.02		
2	ЭМТ	4	73.4	1	23.1	2	0.7			1	49.6
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>73.42</b>	<b>1</b>	<b>23.1</b>	<b>2</b>	<b>0.7</b>	<b>1</b>	<b>0.02</b>	<b>1</b>	<b>49.6</b>

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1.0 сая төгрөгийн 1 алдаа илэрснийг төлбөрийн акт тогтоосон.

### **4.2 Төлбөрийн акт**

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэгт “Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй” 4.7.6 дахь заалтад “Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал” гэж заасныг зөрчин Сумын Орон нутгийн хөгжлийн сангаас Ялалтын хөгжил хоршоонд 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэнд төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сагил сумын Засаг дарга	1	1.0			1	1.0				
<b>НИЙТ</b>		<b>1</b>	<b>1.0</b>			<b>1</b>	<b>1.0</b>				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

М.БАТСУУРЬ/  
/М.БАТ-АМГАЛАН/  
/Г.АМАРМЭНД/

2022 оны 03 сарын 25-ны өдөр